

ЭДИЙН ЗАСГИЙН ДИПЛОМАТ АЖИЛЛАГААГААР ЗӨӨЛӨН ХҮЧ, ЗӨӨЛӨН ХҮЧНИЙ БОДЛОГЫГ ИДЭВХИЖҮҮЛЭХ НЬ

Т.Уянгаа*

***Abstracts:** This article attempts to highlight economic diplomacy as a fundamental policy for national security. Today, economic diplomacy is needed to be seen in complex with national and foreign policies as a multidimensional policy, which should have effects to other foreign policy goals. The theory-oriented research of economic diplomacy, reinforced with soft power policy and soft power resources, is the first attempt to define direct and interconnected ways both to develop and practice them in the future. Soft power (resources) and soft power policy might give double or parallel out-turns to its recipients, which both may lead to positive or negative consequences.*

***Key words:** Economic Diplomacy, Emerging Economies, Soft Policy*

I. Дэлхийн эдийн засгийн тогтолцооны шилжилтийн үе

Шинэ мянган эхлэхэд хүн төрөлхтөн, тэр дундаа хөгжиж буй улс орнууд дэлхийн худалдаа, эдийн засагт жин дарж эхэлсэн бөгөөд үүнд гол нөлөөлсөн хүчин зүйл нь глобалчлал болон техник, технологи, мэдээлэл харилцааны шинэ эриний эхлэл байв. Дэлхийн эдийн засагт шинээр түрэн гарч буй эдийн засгууд (emerging economies) болох Бразил, ОХУ, Энэтхэг болон Хятад улсуудын байгуулсан БРИКС², түүний дотор Хятадын жин нөлөө Бреттон Вүүдсийн³ системд мэдэгдэхүйц нэмэгдэж, нэгэнт тогтсон дэлхийн эдийн засгийн тогтолцоонд


* ХИС-ийн Олон улсын харилцаа, нийгэм судлалын сургуулийн докторант

² <https://www.thebricspost.com/imf-reforms-china-india-brazil-russia-get-greater-say/>

³ ХХ зууны туршид эдийн засгийн дипломат ажиллагаа дэлхийг хамарсан дайнгууд, улс төрийн тогтолцооны ялгаа, зөрчилдөөний улмаас хязгаарлагдмал явж ирж байсан ч өмнөх зуунд олон улсын эдийн засгийн харилцааны гол суурийг тавьж өгсөн юм. Дэлхийн II дайны төгсгөлд 1944 оны 7 дугаар сард дэлхийн 44 орны 730 гаруй төлөөлөгчид АНУ-ын Нью Хэмпшир мужийн Бреттон Вүүдст цуглан дэлхийн худалдаа-эдийн засаг, валют санхүү, зээл, төлбөр тооцооны систем бие болгохоор зорьж гэрээ байгуулсан. Тус Бреттон Вүүдсийн системийн дагуу алт болон ам. долларын харьцааг 1 унц алт 35 доллартай тэнцэж байхаар хатуу тогтоож, бусад улсын валютыг доллартай харьцуулж төлбөр тооцоо хийгдэг байсан. Гэвч олон улсын нөхцөл байдал (Вьетнамын дайн болон газрын тосны хямрал) болон АНУ-ын дотоод санхүүгийн хүндрэлээс шатгаалж 1973 онд АНУ-ын Ерөнхийлөгч Ричард Никсон долларыг алттай хатуу тогтоосон ханшнаас гаргаснаар Бреттон Вүүдсийн систем de facto дуусгавар болж, одоогийн чөлөөт хөвөгч ханшаар тогтоогддог валютын систем бие болсон. Харин тус Бреттон Вүүдсийн бага хурлаар үндэс сууриа тавьсан ОУВС, Шинэчлэлт хөгжлийн олон улсын банк (хожим Дэлхийн Банкны группын нэг хэсэг болсон), ГАТТ (хожим ДХБ болж өргөжсөн) өнөөг хүртэл үүргээ гүйцэтгэж, хүн төрөлхний хөгжилд хувь нэмрээ оруулсаар байгаа билээ.

нөлөөлөхүйц болж түүнийг хөдөлгөөнд оруулав.

Зураг 1.



АНУ-ын манлайлал дор үүсгэн байгуулагдсан тэрхүү либерал олон улсын валют-санхүү, зээлийн шинэ дэг журмын үр өгөөжийг зөвхөн АНУ хүртээд зогсохгүй дэлхийн бусад улс гүрнүүд ч өнөөг хүртэл хүртсээр, энэ нь дэлхийн эдийн засгийн өсөлт болон хүн төрөлхтний амьдралын чанарыг бодитой сайжруулсан түүх юм. Энэхүү түүх хагас зууны туршид амжилт олсон нь зөөлөн хүч буюу Ж. Найн тодорхойлсноор бусдыг өөртөө татах чадвартай хоршиж байсанд оршино. Дэлхийн банкны мэдээгээр⁴ 1960 онд дэлхийн ДНБ 1,37 их наяд ам. доллар байсан бол 2019 онд 87,7 их наяд ам доллар болсон байна.⁵ 1981 онд⁶ дэлхийн хүн амын 42 хувьд ядууралд байсан бол 2015 онд 10 хувь руу буурчээ. Дэлхийн худалдаа⁷ 1947 онд ГАТТ⁸ байгуулагдсан үеэс 2019 он хүртэл 4220 хувиар өсөж, 1995 онд ДХБ үйл ажиллагаагаа эхэлсэн үеэс 2019 оныг хүртэл дэлхийн худалдааны нийт эргэлт жил бүр дунджаар 4,1 хувиар өсч ирэв.

⁴ <https://data.worldbank.org/indicator/NY.GDP.MKTP.CD?end=2018&start=1960&view=chart>

⁵ <https://databank.worldbank.org/data/download/GDP-2019.pdf>

⁶ <https://data.worldbank.org/topic/poverty?end=2018&start=1981>


⁷ https://www.wto.org/french/res_f/statis_f/trade_evolution_f/evolution_trade_wto_f.htm

⁸ Бреттон Вүүдсийн системийн байгууллага болох ГАТТ буюу Тариф болон худалдааны ерөнхий Хэлэлцээрийг 1947 оны 10 дугаар сарын 30-нд 23 улс баталсанаар хүчин төгөлдөр болжээ. 1994 оны 4 дүгээр сарын 14-нд Марракеш хотноо 123 орон гарын үсэг зурснаар ГАТТ шинэчлэгдэн өргөжиж ДХБ байгуулагдсан. ДХБ-ын үндсэн зорилго нь улс орнуудын хоорон дахь худалдааны тарифын болон тарифын бус саад, тогторыг арилгах, чөлөөт худалдааг хөгжүүлэх болон худалдааны маргааныг шийдвэрлэхэд оршино. Түүхэн хөгжлийнхөө үе шат бүрт улс орнуудын худалдаа өргөжихийн хэрээр тус хэлэлцээр олон үе шатуудыг дамжиж, дэлхийн худалдааны харилцааг зохицуулсаар иржээ.

https://www.wto.org/english/res_e/statis_e/trade_evolution_e/evolution_trade_wto_e.htm

График 1.

Дэлхийн худалдааны өсөлт 1948-2018 он



Иймд улам өсөн нэмэгдэж буй дэлхийн эдийн засгийг зохицуулахад Бреттон Вүүдсийн системийн байгууллагуудын үүрэг чухал хэвээр байгаа өнөө үед уг тогтолцоог анх санаачилсан АНУ ч өнөөгийн дэлхийн эдийн засгийн харилцааны өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрч, тус тогтолцоог илүү боловсронгуй болгох тал дээр анхаарч эхэлжээ. Улмаар 2010 онд ОУВС⁹ шинээр гарч ирж буй, хөгжиж буй орнууд болон бага төлөөлөлтэй улсуудын¹⁰ тус байгууллага дахь эзлэх саналын хувийг нийт 6 хувиар нэмсэн бөгөөд шинээр гарч ирж буй улсууд (emerging economies) саналын хувиараа эхний 10 орны тоонд орох болсон боловч¹¹, тус өөрчлөлтийг АНУ-ын Конгресс дөнгөж 2016 онд баталснаар тухайн улсуудын саналын эрх баталгаажсан юм. АНУ-ын үзэж буйгаар Хятад дэлхийн томоохон эдийн засгийн хувьд¹² хөгжиж буй улс гэж өөрийгөө үзэх нь зохимжтой бус бөгөөд эдийн засгийн шударга бус хувиарлалтад гол нөлөө үзүүлж байна гэжээ.

⁹ ОУВС-д дэлхийн 189 орон гишүүнчлэлтэй, олон улсын санхүү, худалдаа, валютын төлбөр тооцоо, гишүүн орнуудын макро эдийн засгийн хүндрэлийг даван туулахад дэмжлэг үзүүлэх зорилготой. ОУВС гишүүддээ тус бүрийн зохих нөөцийн сангаас нь гадна албан ёсны зээлжих тусгай эрх бүхий (Special Drawing Rights-SDRs-олон улсын нөөцийн хөрөнгө) нэмэлт санг бүрдүүлэх боломж олгодог. Нийтдээ 204 тэрбум зээлжих тусгай эрх (283 тэрбум ам. доллар) буюу санхүүгийн багц хуримтлагдсан байсан бол 2016 онд квот болон саналд өөрчлөлт орсоноор тус дүн 2 дахин ихсэж 477 тэрбум зээлжих тусгай эрх (661 тэрбум ам. доллар) болсон байна. 1970 онд ОУВС-гийн валютын нөөцийн багцийн 1 зээлжих тусгай эрхийг анх 0,888671 грамм алтан агуулгатай байхаар тогтоож, Бреттон Вүүдсийн санхүүгийн системийн алт-долларын стандарт нуран унаснаар валютын сагсны ханшаар тооцож гаргадаг болов. Өнөөдөр зээлжих тусгай эрхийн ханшийг ОУВС-гийн чөлөөтэй хөрвөдөг 5 валют болох ам.доллар, евро, фунт стерлинг, иен болон юанийн ханшаар тооцож байна. ОУВС тухайн улсын квотыг тогтоохдоо тухайн улсын эдийн засгийн үзүүлэлтүүд 15 хувь, ДНБ 50 хувь, нөөц хөрөнгө 5 хувь, дэлхийн эдийн засагт нээлттэй байдал 30 хувьд тооцон томъёолж гаргадаг байна.


¹⁰ <https://www.imf.org/external/pubs/ft/ar/2016/eng/quota.htm>

¹¹ <https://www.imf.org/external/np/sec/memdir/members.aspx>

¹² 2017 оны Дэлхийн банкнаас гаргасан тайланд дэлхийн нийт эдийн засаг 80 их наяд доллар, түүнд Хятад хоёрдугаарт буюу 12,2 их наяд ам доллар буюу 15 хувийг эзлэв гэжээ.

График 2.

**ОУВС-нд эзлэх нийт саналын эхний 10 улсын саналын хувь.
2010 оны өөрчлөлтийн өмнө.**




Эх сурвалж. 2016 оны ОУВС-ын тайлан.

2010 оны өөрчлөлтөөс өмнө ОУВС-д дээрх график дээр гарч буй 14 улс нийт саналын 61 хувийг эзэлж байсан бол үлдсэн 39 хувийн саналыг 172 гишүүн нийлээд эзэлж байв.

Харин Хятад улсын хувьд ОУВС, Дэлхийн Банк болон бусад эдийн засгийн байгууллагад эзлэх өөрсдийн саналын хувийг бага байна гэж үзэж байгаа юм. 2019 оны эцсээс ОУВС-ын хүрээнд саналын хувиарлалтанд өөрчлөлт оруулах талаар дахин яригдаж байгаа боловч АНУ үүнийг одоогоор шаардлагагүй гэж үзэж байгаа ажээ. Нөгөөтэйгүүр, АНУ-ын ийнхүү саналын хувь их байгаа нь тус улс эдийн засгийн хориг тавих боломжийг олгож байгаа юм.

График 3.

**ОУВС-нд эзлэх нийт саналын эхний 10 улсын саналын хувь. 2010 оны
өөрчлөлтийн дараа.**



Эх сурвалж. 2016 оны ОУВС-ын тайлан.

Анх ГАТТ байгуулагдаж байх үетэй харьцуулахад дэлхийн худалдааны эргэлт 2018 оны байдлаар 40 дахин, нийт үнэлгээ нь 300 дахин ихэсчээ. 1995 онд ДХБ үйл ажиллагаагаа эхэлснээр нийт эргэлт огцом өсч, жилд дунджаар 4,2 хувийн өсөлттэй, 2018 оны байдлаар хөгжиж буй улсууд худалдааны эргэлт 6,3 хувь байгаа бол хөгжингүй улсууд 3,1 хувьтай байжээ. 2018 оны байдлаар тариф дунджаар 9 хувьтай байгаа нь 1996 оныхоос 19 хувиар бага байгаа юм.

1997-98 оны Зүүн Азийн санхүүгийн хямрал, 2008-2009 оны дэлхийн санхүү-эдийн засгийн хямрал, эдийн засгийн хориг, Brexit, худалдаа, технологийн дайн болон геополитикийн маргаантай асуудлууд, мөн 2020 оны эхнээс эхэлсэн дэлхий нийтийг хамарсан коронавирусын цар тахлаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн зогсонги байдал зэрэг асуудлууд дээр эдийн засгийн дипломат ажиллагааг олон улсын механизмаас гадна илүү тодорхой бүс нутгийн¹³, бүс нутаг хоорондын, хоёр талт эсвэл бие даасан механизмаар зохицуулах чиг хандлага гарсаар байна. Бүс нутгийн Чөлөөт Худалдааны Хэлэлцээрүүд болох Regional Comprehensive Economic Partnership, Trans-Pacific Partnership, Trans-Atlantic Trade and Investment Partnership, “Бүслүүр ба зам” санаачилга, Евразийн Эдийн Засгийн Холбооны интеграци, бүс нутгийн эдийн засгийн бусад санал, санаачлагууд зэрэг нь дэлхийн эдийн засгийн шинэ дэг журам бүрдэхэд нөлөөлж байна. Үүнтэй холбоотойгоор Дэлхийн тэргүүлэх эдийн засагтай G20-ын бодлого, үйл ажиллагаанд шинээр гарч буй эдийн засгуудын жин болон санал нэмэгдэж байна.

II. Эдийн засгийн дипломат ажиллагааг бодлого, стратеги болгох нь

Харилцан хамаарлын өнөө үед хувь хүний аюулгүй байдал, түүний эдийн засгийн аюулгүй байдал (улсын зөөлөн хүч буюу нөөц гэж тодорхойлж болно) аливаа улс орны аюулгүй байдал, эдийн засагтай энэ тэнцүү чухлаар тавигдсаар байна. Орчин үеийн хөгжлийн хурд, дэлхийн нийтийн тулгамдсан асуудлууд зэрэгцэн буй олон улсын эдийн засгийн харилцааны асуудлыг шийдвэрлэхэд шинэ зохицуулалтууд, шинэ эдийн засгийн дэг журам зайлшгүй юм. Шинэ эдийн засгийн дэг журам нь илүү олон талт оролцоотой (*inclusive*), тогтвортой (*sustainable*), тэнцвэртэй (*balanced*), дэвшилттэй (*innovative*), шударга (*fair*) байх зарчимд тулгуурласан байхыг шаардаж байна. Энэхүү олон улсын шинэ орчинд эдийн засгийн дипломат ажиллагааны үүрэг, ач холбогдол улам бүр нэмэгдсээр байгаа бөгөөд үүндээ хөрвөх чадвар бүхий (*жишээ нь: эдийн засгийн өсөлт*) болон зөөлөн хүчний (*жишээ нь: эдийн засгийн хүртээмжтэй байдал*) бодлогыг шаардаж байна.

Шинэ эдийн засгийн дипломат ажиллагааны тухай онолын үндэслэлийг 1999 оноос Английн судлаачид Стэфэн Вүүлкок¹⁴, Николас Бэйн¹⁵ нар бие даасан

¹³ <https://www.worldbank.org/en/topic/regional-integration/brief/regional-trade-agreements>

¹⁴ Stephen Woolcock - Лондонгийн Эдийн засаг, улс төр судлалын сургуулийн Олон улсын харилцааны сургуулийн профессор, тус сургуулийн Олон улсын худалдааны бодлогын нэгжийн захирал

¹⁵ Nicholas Bayne – Лондонгийн Эдийн засаг, улс төр судлалын сургуулийн Олон улсын худалдааны бодлогын

судлагдахуун болгон судалж эхэлсэн. Тэдний тодорхойлтоор “Шинэ эдийн засгийн дипломат ажиллагаа нь олон улсын эдийн засгийн шийдвэр гаргалтын процесс” юм. Тэд шинэ эдийн засгийн дипломатыг зөвхөн олон улсын харилцааны болон олон улсын улс төрийн эдийн засгийн харилцааны онолуудаар тайлбарлахад хангалтгүй бөгөөд харьцангуй эдийн засгийн онол, хүчний онол, хэлэлцээний онол буюу шийдвэр гаргалт, олон улсын байгууллага болон олон улсын дэг журмын онол, олон улсын зах зээл, эдийн засгийн онол, үндэсний ашиг сонирхол болон тохиролцооны рационалист онол, Б. Путнамын давхар тоглоомын онол (Two Level Game), санаачлага гаргах болон өөртөө татах конструктив онолуудаар хамтад нь тайлбарлан судлах шаардлагатай гэж үзжээ. Одоогоор шинэ эдийн засгийн дипломат ажиллагааг хэрэгжүүлж буй арга хэрэгслээр нь гэхээсээ илүү агууллагаар нь тодорхойлох нь илүү оновчтой бөгөөд шинэ эдийн засгийн дипломат ажиллагааны тухай ойлголт яриа, хэлэлцээ явуулах урлаг гэх сонгодог ойлголтоос илүү өргөн хүрээг хамрах болж **бодлого, стратеги, тактик, хөрвөх чадвараар** тодорхойлогдож байна.



Шинэ эдийн засгийн дипломат ажиллагааг явуулахдаа улс төрийн зорилгыг тэргүүлэх чиглэлээ, эсвэл эдийн засгийн зорилгыг тэргүүлэх чиглэлээ гэж авч үзэх нь тэнцвэрийг алдагдуулах талтай.

Шинэ эдийн засгийн дипломат ажиллагаанд гарч болох 3 асуудал:

- Эдийн засаг, улс төрийн хоорондын зөрчил
- Олон улсын болон дотоодын дарамт, шахалт
- Засгийн газар болон бусад оролцогчдын зөрчил

Шинэ эдийн засгийн дипломатын тухай судалгааг онол-аргазүйн түвшинд гаргасан үндэслэгчид Стивэн Вүүлкок, Николас Бэйн нараас гадна бусад судлаачид шинэ эдийн засгийн дипломатыг дараах байдлаар тодорхойлжээ:

- Олон улсын эдийн засгийн шийдвэр гаргалтын процесс... (Nicholas Bayne)

and Steven Woolcock. 2003, 2017)

- Шинэ эдийн засгийн бодлогын асуудлыг авч хэлэлцдэг... (Geoff Berridge and Alan James, 2003.)
- Улс орнуудын хооронд үүссэн аливаа маргаантай эдийн засгийн асуудлыг энхтайвны аргаар шийдэх үйл ажиллагаа... (Zhao Kejin, 2011).
- Үндэсний эдийн засгийн хөгжлийг хангах зорилготойгоор олон улсын хэлэлцээнд улс төрийн арга хэрэгслэлийг хөшүүрэг болгон ашиглах бол, үндэсний улс төрийн тогтвортой байдлыг хангахын тулд эдийн засгийг хөшүүрэг болгон ашиглахыг хэлнэ ... (Maaike Okano-Heijmans. 2011).
- Ялгаатай ойлголт бөгөөд эхний тохиолдолд гадаад бодлогодоо тодорхой улс төрийн зорилго болон стратегийн сонирхолыг биелүүлэхийн тулд эдийн засгийн арга хэрэгсэл ашиглах бол нөгөө талдаа гадаад эдийн засгийн харилцааг хэлнэ... (Lu Yi, 2004 гэжээ).

Дэлхийн эдийн засгийн хүчирхэг гүрнүүд улс төр, цэрэг, дипломатад суурилсан бодлогоо шинэ эдийн засгийн дипломат бодлогоороо орлуулах, түүгээрээ өөрсдийн улс төрийн байр суурийг ч олон улсад харуулах нь ердийн үзэгдэл болж байна. Зөөлөн хүчийг үндэслэгч Ж. Найн тодорхойлсноор эдийн засаг нь өөрөө хатуу хүч боловч эдийн засгийн хөгжлийн сайн үлгэр жишээ загвар нь өөрөө зөөлөн хүч мөн гэжээ. Мөн эдийн засгийн хориг нь хатуу хүчинд тооцогдож болох боловч энэ нь мөн гуравдагч улсын хувьд анхаарлыг нь татаж болох зөөлөн хүчинд тооцогдож болох юм. Тиймээс шинэ эдийн засгийн дипломат ажиллагааг бодлого, агуулгынх нь хувьд зөөлөн болон хатуу хүч гэж ангилж болох юм.

Шинэ эдийн засгийн дипломат ажиллагааны бүрдэл хэсгүүд

Худалдааны дипломат ажиллагаа	Худалдаа, хөрөнгө оруулалт дэмжих, бизнес зөвлөгөө, аялал жуулчлалыг дэмжих, нийгмийн хариуцлагыг дэмжсэн хөрөнгө оруулалт, ЧХХ, Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, anti-dumping, тариф, экспорт импортын лиценз, хувь хэмжээ
Санхүүгийн дипломат ажиллагаа	Мөнгөн тэмдэгтийн SWAP хэлэлцлүүд Валютын ханшийн бодлого, Засгийн газрын бонд худалдан авах, зарах, Актив хөрөнгүүдийг царцаах, Олон улсын төлбөр тооцооны хугацааг баримтлах
Урамшуулал	Зээл, тусламж, өрийг тэглэх, хүмүүнлэгийн тусламж, Технологид нэвтрэх эрх олгох, олон улсын байгууллагуудад гишүүнээр элсүүлэх
Санкции	Эмбарго, бойкот, тусламжаа зогсоох, хөрөнгийн хяналт, хар жагсаалтад оруулах

Маттью Гүүдмэн¹⁶ хэлэхдээ: АНУ-ын түүхийн турш түүний гадаад бодлогод худалдааны бодлого гол цөм байсаар ирсэн боловч өнөөгийн эдийн засгийн хүчний шилжилт явагдаж байгаа үед АНУ гадаад худалдааны эрх ашгаа хангахаас гадна гадаад бодлогодоо эдийн засгийн бодлогыг стратегийн арга хэрэгслэлээ болгох зайлшгүй шаардлагатай. Эдийн засгийн бодлого нь зоосны хоёр талтай адил, улс орны хөгжилд хувь нэмэр оруулах экспорт, хөрөнгө оруулалт болон бусад эдийн засгийн үйл ажиллагааг дипломатын аргаар дэмжихээс гадна, үндэсний аюулгүй байдлаа хангах болон гадаад бодлогын бусад зорилгоо дэмжихийн тулд бусад улсын зан төлөвт нөлөөлж болох санкцаас эхлээд худалдааны хэлэлцээ хүртэлх бүхий л эдийн засгийн арга хэрэгслэлийг хэрэглэхийг хэлнэ гэжээ.

III. Эдийн засгийн дипломат ажиллагаагаар зөөлөн хүч болон зөөлөн хүчний бодлогыг бэхжүүлэх нь

Орчин үеийн шинэ эдийн засгийн тогтолцоо бүрэлдэн буй өнөө үед шинэ эдийн засгийн дипломат ажиллагаа нь гадаад бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн нэг байх хэрэгтэй бөгөөд тиймээс шинэ эдийн засгийн дипломат ажиллагаагаар дамжуулан зөөлөн хүчний бодлого хэрэгжих боломжтой юм. Саяханы энгийн жишээ бол Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга БНХАУ-д дэгдсэн цар тахалын нэн хүнд үед зоримог ажлын айлчлал хийж, 30 мянган толгой хонь буцалтгүй тусламж болгож бэлэглэхээр шийдвэрлэснээ мэдэгдсэн нь эдийн засгийн дипломатын хамгийн энгийн нэг хэлбэр байсан бөгөөд энэ нь монгол ардын цэцэн үгэнд зүйрлэснээр “тэнүүн явахад тэмээгээр тусалснаас тэвдэж явахад тэвэнгээр тусалсан нь дээр” гэдэгтэй агаар нэгэн буюу зөөлөн хүчний бодлогын тод илрэл болж эдийн засгийн дипломатын уран нүүдэл хийж чадсанд утга санаа нь оршиж байгаа билээ. Үүнээс гадна 2003 онд Монголын Засгийн газар хуучин ЗХУ-д төлөх “их өр”-ийг тэглэж чадсан нь аанай л эдийн засгийн дипломатын сайн жишээ болж, Монгол Улс олон улсын анхаарлыг татаж эхэлсэн нь өөрөө зөөлөн хүчний бодлогын үр дүн болж, үүнийг дагаад Монгол Улсын олон улсын зээлжих чансаа эрс дээшилж, харин өргөн утгаараа үндэсний аюулгүй байдал баталгаажсан юм.

Ж. Найн тодорхойлсоноор зөөлөн хүч бол соёл, улс төрийн үнэт зүйлс, гадаад бодлогоор бусдыг бишрүүлэн татах чадвар гэж тодорхойлсон. Харин өнөөдөр дэлхийн эдийн засаг харилцан хамааралтай болсон энэ үед Ж. Най өөрийн сүүлийн үеийн зөөлөн хүчний судалгаандаа эдийн засаг буюу хатуу хүч нь мөн зөөлөн хүч болж болох бөгөөд улс орон бүр зөөлөн хүчний бодлогодоо хандах хандлага өөр

¹⁶ Matthew P. Goodman - АНУ-ын Стратеги, олон улс судлалын төвийн ахлах дэд ерөнхийлөгч, олон улсын эдийн засгийн бодлого, тэр дундаа Ази, Номхон далайн бүсийн ахлах зөвлөх. 2002-2004 онд АНУ-ын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлд олон улсын эдийн засгийн асуудал эрхэлж, G20, АРЕС зэрэг томоохон арга хэмжээнд зохицуулагч, Төрийн департаментад эдийн засаг, эрчим хүч, хөдөө аж ахуйн асуудал хариуцсан зөвлөх, Goldman, Sachs & Co.-д хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөх, 1988-1997 АНУ-ын Сангийн яаманд олон улсын эдийн засагч, Олон улсын харилцааны Жон Хопкинсын их сургуульд олон улсын харилцааны чиглэлээр магистрын зэрэг, Лондонгийн Эдийн засаг, улс төрийн сургуульд эдийн засгийн бакалаврын сургалт дүүргэжээ. Council on Foreign Relations буюу Гадаад бодлогын зөвлөлийн гишүүн.

бөгөөд онцлоготой гэдгийг 2013 онд нэмж тайлбарласан. Тэрбээр АНУ-ын зөөлөн хүч илүү нийгэм, ард иргэдийн оролцоотой байдаг бол, харин Хятад, ОХУ-ын зөөлөн хүчний бодлогод Засгийн газрын оролцоо их гэсэн байна.

Тиймээс орчин үед их гүрнүүд болон аж үйлдвэржсэн хөгжингүй орнууд зөөлөн хүчний бодлогоор өөрийн нөлөөний хүрээ, үндэсний ашиг сонирхолоо хамгаалахад ач холбогдол өгсөөр байна. **Зөөлөн хүч** бол нөөц, боломж, харин **зөөлөн хүчний бодлого** бол хүч, чадал, аюулгүй байдлын нэг баталгаа ажгуу. Зарим өрнөдийн судлаачид Ж. Най зөөлөн хүчний үзэл баримтлалдаа стратегийг нь гаргаж ирээгүй гэж шүүмжилсэн нь зөөлөн хүч бусдыг бишрүүлэн татах нөөц, боломжоо харуулсанаас биш, үүгээрээ дамжуулан ямар зөөлөн хүчний бодлого явуулж байгааг гаргаж чадаагүй гэжээ.

Иймээс, гадаад бодлогодоо шинэ эдийн засгийн дипломат ажиллагааг зөв бодлого, зарчим, зөв арга хэрэгсэлээр явуулж чадвал зөөлөн хүч, зөөлөн хүчний бодлого аль аль нь дагаад бэхжихээс гадна аюулгүй байдлаа баталгаажуулах боломжтой юм.





График 1.

Зөөлөн хүч, Эдийн засгийн дипломат ажиллагаа болон Зөөлөн хүчний бодлогын хоорондын шилжилтийн үйл явц, стратеги


Зөөлөн хүч, эдийн засгийн дипломат ажиллагаа, зөөлөн хүчний бодлогын уялдааг БНХАУ-ын жишээн дээр дараах байдлаар ангилж болно.

Зөөлөн хүч	Эдийн засгийн дипломат ажиллагаа	Зөөлөн хүчний бодлого
☐ Эдийн засгийн нөөц боломж ☐ Худалдааны либералчлал ☐ Өрийг тэглэх ☐ Хөрөнгө оруулалт	☐ Бүс, зам санаачлага ☐ Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк ☐ Чөлөөт худалдааны бүсүүд ☐ 21 зууны далайн торгоны зам ☐ Чөлөөт худалдааны хэлэлцэрлүүд	☐ Зах зээлээ тэлэх ☐ Аюулгүй байдлаа хангах ☐ Дэлхийн улс төрийн томоохон тоглогч байх ☐ Хятад мөрөөдөл

Дээрхээс дүгнэн тодорхойлвол, *Шинэ эдийн засгийн дипломат ажиллагаа бол зөөлөн болон хатуу хүчийг өөртөө агуулсан үндэсний аюулгүй байдлыг хангасан, гадаад бодлогын чиг шугамд нийцсэн, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг давхар шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулсан бие даасан бодлого, процесс, үр дүн юм.* (Т. Уянгаа) Нэг үгээр хэлбэл, эдийн засгийн дипломат ажиллагаа бол аюулгүй байдлын бодлого юм.



Өмнөд Калифорнийн их сургуулийн дэргэдэх Олон нийтийн дипломатын судалгааны төв 2003 оноос эхлэн зөөлөн хүчний судалгааг хийж байгаа бөгөөд жил бүр **зөөлөн хүчний** дэлхийн чансааг улс орон бүрээр эрэмбэлж, түүнд ямар хүчин зүйлс, нөөц нөлөөлж байгааг гаргаж байна. 2019 оны сүүлийн тайлангаар Засгийн газрын бодлого, эдийн засаг, бизнес, идэвхи оролцоо, боловсрол, дижитал хөгжил, соёл зэрэг тодорхой шалгууруудаар гаргаж, харин олон нийтийн санал асуулгын үндсэн дээр гадаад бодлого, нөхөрсөг хүнлэг байдал, амьдралын нөхцөл, хоолны соёл, технологийн бүтээгдэхүүн, тансаг хэрэглээ, глобал соёл зэрэг шалгууруудаар дэлхийн зөөлөн хүчтэй улсуудын чансааг эрэмбэлжээ.



Эх сурвалж: The Soft Power 30, A Global Ranking of Soft Power 2019

Эдийн засаг, бизнесийн шалгуурыг дараах үзүүлэлтүүдээр гаргасан байна: Үүнд, Өрсөлдөх чадварын индекс, ДНБ-тэй харьцуулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт, ДНБ-тэй харьцуулахад глобал патент эзэмшигчийн хувь, эдийн засгийн эрх чөлөөний индекс, авлигын индекс, глобал инновацийн индекс, R&D-д зориулсан хөрөнгийн зарцуулалт, бизнес эрхлэх боломж, ажилгүйдлийн түвшин,

үйлвэрлэлийн бүтээгдэхүүний экспорт болон Hi-tech экспортын харьцаа, хүн амын орлогод харьцуулсан start-up төслийн үнэлгээ, ДНБ-тэй харьцуулахад сүүдрийн эдийн засгийн эзлэх хувь, хүн амын насжилт, орлогын тэгш бус байдал, Засгийн газартаа итгэх итгэл, хүн амын амжиргааны нөхцөл, Think Thank байгууллага, гадаадад үзүүлж буй буцалтгүй тусламжийн хэмжээ, олон улсын байгууллагууд дахь гишүүнчлэл, визгүй зорчих улсын тоо зэргийг оруулжээ.

2018 оны дэлхийн топ 30 зөөлөн хүчтэй улсуудын жагсаалтыг Англи, Франц тэргүүлж, 27-р байранд Хятад, 28-р байранд ОХУ орсон бол 2019 оны тайланд Хятад байраа хадгалж, харин ОХУ 30-р байрт ухарсан байна.

1.	АНГЛИ	1.	ФРАНЦ
2.	ФРАНЦ	2.	АНГЛИ
3.	GERMAN	3.	GERMAN
4.	АНУ	4.	ШВЕД
5.	ЯПОН	5.	АНУ
6.	КАНАД	6.	Швейцари
27.	ХЯТАД	27.	ХЯТАД
28.	ОХУ	30.	ОХУ

2019 оны Азийн зөөлөн хүчтэй улсуудыг Япон, Өмнөд Солонгос тэргүүлсэн бол Хятад 4, Энэтхэг 8-р байрт оржээ. 2019 оны дэлхийн топ эдийн засаг, бизнесийн зөөлөн хүчтэй улсуудыг Сингапур тэргүүлсэн бол АНУ 5-р байрт, Япон 7, Өмнөд Солонгос 9-р байранд орсон байна.

2019	2019
1.	1.
2.	2.
3.	3.
4.	4.
5.	5.
6.	6.
7.	7.
8.	8.
9.	9.
10.	10.


Дээрхи судалгаагаар аливаа улс бусдыг өөртөө бишрүүлэн татах чадваруудыг гаргаж ирсэн нь Ж. Найн тодорхойлтоор зөөлөн хүч юм. Тиймээс зөв эдийн засгийн дипломат ажиллагаа явуулсанаар аливаа улс зөөлөн хүчээ улс орныхоо бүхий л салбарт эдийн засгийн арга хэрэгсэлээр дэмжих нөхцөл бүрдэх юм. Харин зөөлөн хүчний бодлого бол тухайн зөөлөн хүчийг ашиглаж тус улс ямар зорилго, ашиг сонирхолыг агуулж байгаагаараа ялгаатай юм. Улс орны зөөлөн хүчний бодлого болон хүчний тэнцвэр харилцан ялгаатай ч, гаднаас ирж буй зөөлөн хүчний

бодлогыг аливаа улс зөв бодлого баримталсанаар тогтоон барих боломжтой. Өөрөөр хэлбэл, гаднаас ирж буй зөөлөн хүч нь шууд зөөлөн хүч болохгүй бөгөөд түүнийг хэрхэн хүлээж авахаас хамаарна. Үүний нэг жишээ нь: бүс нутгийн төдийгүй дэлхийн нөлөө бүхий улсын хувьд Өмнөд Солонгосын **зөөлөн хүч** болох урлаг, соёлын давалгаа болон технологийн үсрэнгүй хөгжил нь дэлхий нийтээр хүчээ авч дэлхийн улсуудын анхаарлыг татаж байгаа боловч, энэ нь өөр нэг улсын соёл, заншилд хэт ихээр нөлөөлөхгүй байх эсэх нь түүнийг хүлээн авагч улсын зохицуулалт бодлогоос хамаарна. Тиймээс орчин үеийн олон улсын харилцаанд аль ч улс гүрэн зөөлөн хүчний бодлогыг явуулах боломжтой болсон бөгөөд энэ нь цэрэг зэвсэг, эдийн засгийн хүч сул улсуудад өөрийн улсын ашиг сонирхол, аюулгүй байдлаа хамгаалахад чухал юм. Үүнд эдийн засгийн дипломат ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.

Олон улсын болон дотоодын судалгааны ажлуудад зөөлөн хүч, зөөлөн хүчний бодлого хоёрын ялгааг гаргасан судалгаа болон тэр дундаа тэдгээрийг эдийн засгийн дипломат ажиллагаатай уялдуулан гаргасан судалгаа төдийлөн сайн гараагүй байгаа бөгөөд үүнийг онол, судалгааны аргазүйн түвшинд нарийн судлан үндэсний аюулгүй байдлын асуудал болгон авч үзэх шаардлагатай юм.

IV. Монгол Улсын эдийн засгийн дипломат ажиллагааны томоохон боломжууд

- Гурван улсын корридорын төсөл, хөтөлбөрүүдийн хүрээн дэх хийн хоолойн асуудал;
- “Туравдахь хөрш”-ийн бодлогын хүрээнд ноос, ноолууран бүтээгдэхүүний экспортыг өргөжүүлэх, GSP+ болон агаарын тээврийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөрүүд;
- Зүүн хойд Азийн эрчим хүчний нэгдсэн сүлжээ байгуулах стратеги;
- Бүслүүр, Замын төсөл, хөтөлбөрүүдэд оролцоогоо өргөжүүлэх;
- Газрын тос боловсруулах үйлдвэрийг барьж байгуулах;
- Монгол Улсын хэрэгжүүлж буй уул, уурхай стратегийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг үндэсний аюулгүй байдалд нийцүүлж, засаж сайжруулах;



ДҮГНЭЛТ

Шинэ эдийн засгийн дипломат ажиллагаа бол зөөлөн болон хатуу хүчийг өөртөө агуулсан үндэсний аюулгүй байдлыг хангасан, гадаад бодлогын чиг шугамд нийцсэн, дэлхий нийтийн тулгамдсан асуудлыг давхар шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулсан бие даасан бодлого, процесс, үр дүн юм.

1999 онд “The Washington Post” сонины шалгаруултаар Чингис хааныг “Мянганы суут хүнээр тодруулж”, 2005 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг дэлхий нийтээр тэмдэглэн өнгөрөөх тусгай тогтоол гаргаж байв. Учир нь Монголын Их Эзэнт гүрний үед олон улсын харилцаанд “их гүрэн” хэмээх ойлголтын эрхзүйн үндэс тавигдаж, чөлөөт худалдааны үзэл санаагаар Өрнө, Дорно холбогдож, шашны эрх чөлөө дэлгэрч, олон улсын мэдээллийн сүлжээ буй болж, олон улсын болон дипломатын эрхзүйн үндэс суурь тавигдаж, тэдгээр нь дэлхий дахины хөгжлийг урагш ахиулахад шийдвэрлэх түлхэц үзүүлсэн гэж НҮБ-ын тогтоолд тэмдэглэжээ. **Монголын Энхжингийн үед Хятад, Энэтхэг, Перс, Араб, Грек болон Өрнөд Европын худалдаачид монголчуудын сэргээн буй болгосон аюулгүй, найдвартай худалдааны их замаар чөлөөтэй арилжаа хийх болсон юм.**¹⁷ Монголын эзэнт гүрний эдийн засгийн дипломат ажиллагаа нь хоёр талт худалдаагаар хязгаарлагдаагүй байсан бөгөөд тив хоорондын худалдааг зохицуулахдаа олон улс хоорондын харилцааг ***их амар амгалангийн зарчим дээр үндэслэсэн худалдааны бодлогыг*** хэрэгжүүлж байжээ. Харин орчин үеийн шинэ эдийн засгийн дипломат ажиллагааны үндэс суурийг АНУ тавьсан. XX зуунд ч мөн эдийн засгийн дипломат ажиллагаа нь их гүрний бодлого байв. АНУ-ын эдийн засгийн дипломат ажиллагаа нь олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын эрхзүйн зохицуулалт, хэм хэмжээг тогтоох, энэ нь зах зээлийн эдийн засаг, ардчилалын үнэт зүйлс дээр суурилж байсан учир амжилттай хэрэгжжээ.

Монголын эзэнт гүрний эдийн засгийн дипломат ажиллагаа, АНУ-ын эдийн засгийн дипломат ажиллагаа хоёулаа Их гүрний бодлого байсан бөгөөд¹⁸ хоёулаа өөрсдийн гэсэн ***үнэт зүйлс дээрээ суурилсан*** олон улсын хэм хэмжээг тогтоож байснаараа ижил бөгөөд иймдээ ч амжилттай хэрэгжиж байжээ.

XX зууны туршид эдийн засгийн дипломат ажиллагаа эрчимтэй хөгжиж ирсэн бөгөөд түүнд оролцогчдын тоо нэмэгдсэнээр зөвхөн их гүрнүүд бус, бусад улсуудын үүрэг нэмэгдсэн нь олон талт эдийн засгийн дипломат ажиллагааны ач холбогдол нэмэгдэхэд нөлөөлжээ. Олон талт эдийн засгийн дипломат ажиллагааны нэг сонгодог жишээ болох Европын Холбоо нь ***нэгдсэн Европ гэсэн нэгэн үнэт зүйлс дээр*** суурилсан учир эдийн засгийн шинэ сорилтуудтай тулгарч байгаа боловч нэгдмэл Европын аюулгүй байдлаа хадгалж чадах юм. XXI зуун гарснаар глобалчлал, дижиталчлал хосолсноор шийдвэрлэх асуудал нь улс орнуудыг

¹⁷ Д. Уламбаяр. Монгол, Өрнөдийн харилцаа эрт, эдүгээ. УБ. 2004, 66-68 дахь тал

¹⁸ Zbigniew K. Brzezinski. The Grand Chessboard: American Primacy and Its Geostrategic Imperatives. Basic Books, N.Y.: 1997, pp. 20-21

хооронд нь улам бүр харилцан хамааралтай болгож, түүнчлэн эдийн засгийн дипломат ажиллагааг тусгаар тогтносон улс бүхэн явуулах зайлшгүй шаардлага тулгарч байна. Өнөө үед олон улсын харилцааны олон туйлт систем бүрэлдэж байгаа нь олон талт эдийн засгийн дипломат ажиллагааны хэлбэр, бүтцүүд бүс нутгийн хэмжээнд болон тив хооронд олноор нэмэгдэх болсон. Жишээ нь: Евразийн эдийн засгийн холбоо, Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын хөгжлийн банк, “бүслүүр, зам” мега санаачилга зэргийн нэрлэж болох юм.

Эдийн засгийн дипломат ажиллагаа нь дотоод болон гадаад бодлогын аль ч чиглэлд шууд эсвэл зэрэг нөлөөлж болох учир улс орон бүр өөрийн онцлог нөхцөл байдалд нийцсэн эдийн засгийн дипломат ажиллагаагаа тодорхойлж явуулах нь зүйтэй. Чингэхдээ эдийн засгийн дипломат ажиллагаагаа ямар үнэт зүйлс, зарчим дээр явуулахаа суурь болгон гаргаж ирэх шаардлагатай. Эдийн засгийн дипломат ажиллагаа нь олон улсын болон дотоодын бодлого, нөхцөл байдал, цаг хугацааны хүчин зүйлсийн үр дүнд гарч ирэх процесс, үйл ажиллагаа, үр дүн учир түүнийг зохицуулсан тусгайлсан үзэл баримтлал, бодлогын баримт бичиг шаардлагагүй юм. Харин эдийн засгийн дипломат ажиллагаа тус бүрээр нь төлөвлөгөө, хэрэгжилт, үр дүнг тооцож гаргадаг байх нь чухал. Эдийн засгийн дипломат ажиллагааг зөв бодлого, зөв зарчим, зөв арга хэрэгсэлээр явуулж чадвал зөөлөн хүч, зөөлөн хүчний бодлого хоёулаа бэхжих бүрэн боломжтой юм.

НОМЗҮЙ

- Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010.
Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал, 2011.
Монгол Улсын эдийн засгийн гадаад харилцааны хөтөлбөр, 2015.
Bayne, Nicholas and Woolcock, Stephen. The New Economic Diplomacy. 4th Edition. Decision-making and negotiation in international economic relations..NY: Routledge, 2017.
Gilpin, Robert. The Political Economy of International Relations. Princeton University Press, 1987.
Spero E. Joan, Hart A. Jeffrey. The Politics of International Economic Relations. 6th Edition. Wadsworth Publishing, 2002.
Nye, J.S. Soft Power: The Means to Success in the World Politics, 2004.
Уламбаяр, Д. “Эдийн засгийн дипломат ажиллагаа: онол-түүх, орчин үеийн зангилаа асуудалд”. Олон Улс судлал сэтгүүл, №2, 3, 2011.
Уламбаяр, Д. Монгол, Өрнөдийн харилцаа эрт, эдүгээ. УБ, 2004.
Бор.Ж. Олон Улсын харилцааны онолын сэтгэлгээний хөгжилд Монголчуудын оруулсан хувь нэмэр. УБ, 2019.
Parallel Perspectives on the Global Economic Order. A US.-China Essay Collection. CSIS. September 2017.
O’Sullivan, Micheal. The Levelling: What’s Next After Globalization. 2019.
Rodrik, Dani. The Globalization Paradox: Democracy and the Future of the World Economy. W. W. Norton & Company, 2011.
Jun, Zhang. Director-General of the Department of International Economic Affairs, “Ministry of Foreign Affairs China’s Economic Diplomacy Entered the Entered the New Era”. Foreign Affairs Journal. (April 2017).

- Goodman, Matthew P. ARIA in Action. The Benefits of Economic Diplomacy. CSIS. 2019. (Senior Vice President; Simon Chair in Political Economy and Senior Adviser for Asian Economics)
- Goodman, Matthew P. "Economics as a strategy". Volume 3. Issue 1. CSIS January 2014.
- Neves, Miguel Santos (2017). "Economic diplomacy, geo-economics and the external strategy of Portugal". JANUS.NET e-journal of International Relations, Vol. 8, No. 1, (May-October 2017).
- "A new type of Soft Power: Country branding". International Journal of Cultural and Social Studies. Vol. 4., (Issue 1), 2018.
- Patalakh, Artem. "Assessment of Soft Power Strategies: Towards an Aggregative Analytical Model for country-focused Case Study Research". CIRP. XXII (76) 2016, 85-112.
- McKinsey and Co. "Globalization in Transition. The future of trade and value-chains". January 2019.
- The Global Competitiveness Report. World Economic Forum, 2018.
- "Economic Diplomacy, Soft Power, and Taiwan's Relations with Indonesia. Contemporary Chinese Political Economy and Strategic Relations". : An International Journal. Vol. 2, No. 3, (December 2016): 1173-1194
- Lee, Sook Jong and Melissen, Jan. Public Diplomacy and soft Power in East Asia. New York: Palgrave Macmillan, pp. 1-10.
- China's Rising Economic Soft Power. Asia Dialogue. 2016.
- EU economic diplomacy strategy. Policy Department. European Parliament, 2017.
- Japan Economic Diplomacy. Blue Book, 2019.
- Goodman, P. Matthew. Asia Reassurance initiative Act in Action: The benefits of Economic Diplomacy. May 23, 2019.
- Nye, J.S. "Smart power: in search of the Balance between Hard and Soft Power." Democracy: A Journal of Ideas. 2016.
- Soft Power 30. USC Center on Public Diplomacy. 2019.
- "Emerging Issues in Economic Diplomacy. Economic Diplomacy Initiative." (April 2020): Harvard Kennedy School for Science and International Affairs.